

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН АВЛИГААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ 2014 ОНЫ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2014 он

Улаанбаатар хот

№	Гүйцэтгэх ажлын хүрээ	Гүйцэтгэлийн үйл ажиллагаа	Биелэлт
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа			
Нэг. Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох			
1	Боловсрол, шинжлэх ухааны салбарын Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх	Салбарын Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулна;	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/125 дүгээр тушаалаар “Боловсрол, шинжлэх ухааны салбарын авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2014 оны ажлын төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүллээ. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах, харьяа байгууллагуудад хүргүүлэхн ажиллаласан. Төрийн өмчийн яамны харьяа байгууллагуудын төлөвлөгөө болон тушаалын биелэлтийг эрчимжүүлэх талаар Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 2/6196 тоот албан бичгийг хүргүүлэн харьяа байгууллагуудаас хийсэн ажлын тайлан нэгтгэн авч байна.
2	Боловсрол, шинжлэх ухааны сайдын томилдог захирал, дарга нарын 2014 оны үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлыг тусгах, хэрэгжүүлэх	Үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээнд авлигын эсрэг авах арга хэмжээний заалтыг оруулж гэрээний биелэлтийг дүгнэсэн байна.	Харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудтай 2014 онд байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээнд Авлигаас урьдчилан сэргийлэх болон Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжыг

			<p>хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой заалтуудыг оруулсан.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ”-д заасны дагуу гэрээг үнэлэх учраас авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлд хийсэн ажлыг 11 дүгээр сард дүгнэх боломжгүй байна.</p>
3	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамны удирдлагын арга барилыг боловсронгуй болгох, албан хаагчдын чадвар, хариуцлага, ажлын үр дүн, чанарыг дээшлүүлж олон улсын нийтлэг жишгийн дагуу ажиллах зорилгоор яамны хэмжээнд чанарын удирдлагын олон улсын ISO 9000, стандартыг нэвтрүүлэх арга хэмжээг авах.</p>	<p>Олон улсын ISO 9000 стандарт, ажил, үйлчилгээний чанарыг хангах чиглэлээр зөвлөх үйлчилгээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны яаманд Олон улсын ISO 9000 стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хэсгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/120 дугаар тушаалаар баталж ажиллах чиг үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээг зааж өгсөн.</p> <p>2014 онд энэхүү ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Яамны албан хаагч бүрийн үйл ажиллагааны зураглалын гаргуулан авч чанарын удирдлагын дүн шинжилгээг хийсэн. • Яамны үйл ажиллагааны зураглалын дагуу ажлын байрны дүн шинжилгээг хийж дуусгасан • Ажлын байрны шинжилгээний дүн ба үйл ажиллагааны зураглалын үр дүнг харилцан уялдуулах, шаардлагтай өөрчлөлт, сайжруулалт хийхээр ажиллаж байна. /Яаманд мөрдөгдөж байгаа эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актуудыг өөрчлөх, нэгтгэх, хүчингүй болгох зэрэг/ <p>Яамны алба хаагчдаас иргэд байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээний төрөл ангилалаар үйл ажиллагааг төрөлжүүлэн тодорхой</p>

			<p>болгох ажлын ажлыг эхлүүлэн хэрэгжүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Яамны хэмжээнд үйл ажиллагааны иж бүрэн зураглалыг гаргахаар бэлтгэл ажиллууд хийгдэж байна. Ингэснээр газар, хэлтсүүдийн үйл ажиллагааны давхардлыг бүрэн арилгаж иргэд, аж ахуй нэгж байгууллагад тодорхой түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдэнэ. • Хэрэглэгчид зориулсан үйл ажиллагааны зураглалыг боловсруулж гаргах ажил хийгдэж байна. Энэхүү үйл ажиллагааны иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад зориулж хэрэгцээ, шаардлагатай мэдээ, мэдээллийг хаанаас хэрхэн түргэн шуурхай авч болох талаарх зөвлөмж үйлчилгээг үзүүлэх юм.
4	<p>Боловсрол, шинжлэх ухааны салбарын тодорхой албан тушаалтны “Ёс зүйн дүрэм”-ийн шинэчлэх, дагаж мөрдүүлэх арга хэмжээг авах.</p>	<p>Салбарт хэрэгжиж буй ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг судлан шинэчлэх, зохих нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээг авна.</p>	<p>Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургуулийн багш болон удирдах албан тушаалтнуудын “Ёс зүйн дүрэм”-ыг шинэчилэн батлуулхаар дүрмийн төслийг боловсруулж төслөөр Монголын багш нарын холбоо, Нийслэлийн боловсролын газар, Багшын мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран хэлэлцүүлэг хийж түүнээс гарсан санал, дүгнэлт болон яамны цахим хаягаар ирүүлсэн санал дүгнэлтүүдийг дүрмийн төсөлд тусган эцэслэн шийдвэрлэсэн.</p> <p>Энэхүү дүрмийн төсөлд хөдөө орон нутгийн багш, удирдах албан тушаалтнууд бүрэн хамрагдаж санал, дүгнэлт өгсөн.</p> <p>Мөн Боловсрол, шинжлэх ухааны яамны болон харьяа байгууллагууд өөрсдийн мөрдөж</p>

			<p>байгаа дүрэм, журамд Авлига, ашиг сонирхлын эсрэг заалтуудыг хууль тогтоомжид нийцүүлж бүрэн тусгаж оруулсан.</p> <p>Монгол Улсын Боловсролын их сургууль нь “Багшийн журам”, “Ёс зүй дүрэм” –ийн шинэчлсэн төслийг боловсруулж сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулхаар ажиллаж байна. Мөн “Сургуулийн дотоод журам”, “Хөдөлмөрийн гэрээ”-нд Авлига, ашиг сонирхлын талаарх заалтуудыг оруулсан байна.</p> <p>Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургууль нь ажлын байрны тодорхойлолт болон үр дүнгийн гэрээ болон бүх төрлийн бусад гэрээ, хэлэлцээрт Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх заалтыг оруулж өгсөн.</p>
5	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх болон Хууль сурталчилах талаарх мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авах.</p>	<p>Яамны болон харьяа болон байгууллагуудын дунд сургалт тэмцээн, сургалт зохион байгуулна.</p>	<p>1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны “Сургалт зохион байгуулах, зардал гаргах тухай” А/90 дугаар тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны яам, Аймаг, нийслэлийн боловсролын газар, харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудад зориулсан 100 хүн оролцсон “Захиргааны эрх зүй, хүний нөөцийн мэдлэг, шинэчлэл” сэдэвт сургалт зохион байгуулсан.</p> <p>Энэхүү сургалтын үр дүнд сургалтанд хамрагдсан албан тушаалтнууд өөрсдийн байгууллага хууль, тогтоомжын хэрэгжилтийг сайжируулах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулах, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар, өдөр тутам тулгардаг асуудлыг хичээл заасан АТГ-ын ажилтан н.Мөнхжаргалаас бүрэн дүүрэн хариулт авсан.</p>

			<p>2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Багш нарын мэргэжил дээшлүүлэх, давтан сургах тухай” А/305 тоот тушаалын дагуу үргэлжилсэн сургалтын хүрээнд багш нарт “Авлига урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт сургалтыг нийт 95 хамарсан сургалтыг зохион байгууллахаар ажиллаж байна.</p> <p>3. Тус яаманд хэрэгжүүлж байгаа Чанарын удирдлагын ISO 9001 төслийн хүрээнд дараах сургалтуудыг хийж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• “Чанарын удирдлагын эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэх арга хэлбэр” сургалтыг ажлын хэсгийн хүрээнд зохион байгуулсан;• “Чанарын удирдлагын эдийн засаг” сургалтыг ажлын хэсгийн хүрээнд;• “ISO 9001:2008 стандартын ерөнхий танилцуулга” сургалтыг яамны нийт албан хаагчдын дунд тус тус зохион байгуулсан. <p>4. Монгол Улсын Боловсролын их сургууль Авлигатай тэмцэх газартай хамтран Авлигын эсрэг хууль суртачилах чиглэлд тус сургуулийн захирал, дэд захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирал, албадын дарга, нягтлан бодогч, тэнхимийн эрхлэгч нарийг оролцуулан нийт 75 хүний хамарсан сургалт зохион байгуулсан. Энэхүү сургалтаар Авлигын талаарх ойлголт, ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн урьдчилэн сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэн тохиолдолд хэрхэн яаж шийдвэрлэх, хэнд хаана хандах талаар өдөр тутам тулгардаг асуудлын талаар сургалтанд хамрагдагсадад заасан.</p>
--	--	--	---

Байгууллагын ил байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа			
Хоёр. Эрх зүйн орчин			
6	Улсын Их Хурал, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хууль, тогтоолын төсөлд иргэдийн санал бодол оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авах.	Холбогдох төслүүдийг цахим хуудсанд байршуулах болон иргэд олон нийтийн санал бодлыг тусгах.	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамнаас боловсруулж байгаа хууль тогтоомж болон Засгийн газрын тогтоолын төслүүдийг яамны цахим хуудсан www.meds.gov.mn –ны ХЭЛЭЛЦҮҮЛЭГ хэсэгт байршуулж сонирхогч этгээдүүдээс санал, хүсэлт авч хэвшсэн.</p> <p>Холбогдох мэргэжлийн холбоод болон харьяа байгууллагуудад хүргүүлэн хэлэлцүүлгийн үр дүн болон санал, дүгнэлтийг олон нийтийн санал хүсэлтийг судалж хууль, тогтоомж, шийдвэрийн төсөлд тусгах талаар холбогдох ажлын хэсгүүдэд үүрэг өгч төсөлд тусгаж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Монголын боловсролын шинэчлэлийн төсөл • Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтны ёс зүйн дүрэм • Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролын үнэлгээний журмын төсөл г/м төслүүдэд иргэд, байгууллагаас нээлтэй санал, хүсэлт авсан болно.
7	Боловсрол, шинжлэх ухааны яамнаас олгож буй тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох, зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээ, мэдээлэлийг хялбар, чирэгдэлгүй нээлттэй болгох арга хэмжээг авах.	Тусгай зөвшөөрөл, лиценз, эрх, зөвшөөрөл олгох болон эзэмшигчийн нэр хаяг үйл ажиллагааны чиглэлийн талаарх мэдээ мэдээллийн ил тод, шуурхай байдлыг хангах.	Боловсрол, шинжлэх ухааны цахим хуудсан www.meds.gov.mn -д иргэд, байгууллагууд нэвтрэн орж өөрт хэрэгцээ шаардлагатай байгаа тусгай зөвшөөрөлийг ямар ямар баримт бичиг бүрдүүлж ямар газар, хэлтэс уг тусгай зөвшөөрөл хамаарч байгааг тодорхой оруулж өгсөн.

			<p>Газар, хэлтсүүдээс олгож байгаа зөвшөөрлүүдийн төрөл түүнийг авхад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ хэсэгт мөн оруулсан.</p> <p>Ингэснээр иргэд аж ахуй нэгж байгууллагууд өөрийн хүссэн мэдээ, мэдээлэлээ чөлөөлтэй цаг алдалгүй авах боломжтой болсон.</p> <p>Мөн яамны цахим хуудсаар нэвтэрч мэдээлэл авах боломжгүй иргэд Засгийн газрын 11-11 төвөөр, яамны угтах үйлчилгээнээс өөрсдийн хүссэн тусгай зөвшөөрөл, лиценз, эрх, зөвшөөрөлийн талаарх мэдээлэл, аль газар, хэлтсээс ямар мэргэжилтэн олгодог эсэх талаар бүрэн дүүрэн мэдээлэл авдаг боломж бүрэн нээгдсэн. Энэ талаар иргэд байгууллагууд нилээд тааламжтай хүлээн авч байгаа.</p>
8	Яамны болон харъяа байгууллагуудын албан хаагчдад ёс зүйн зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.	Ёс зүйн зөрчлийн талаарх бүртгэл хөтлөж гарч байгаа зөрчилд дүн шижилгээ хийх, шийдвэрлэлтийг мэдээллийг бэлтгэх.	Боловсрол, шинжлэх ухааны яам болон харъяа байгууллагууд ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтануудад хариуцлага тооцож дахин хариуцлага алдагдахаас урьдчилан сэргийлж холбогдох алба нэгжид мөрдөж ажиллах зөвлөмж, заавар хүргүүлэн ажиллаж байна.
		Яамнаас батлан гаргаж нийтээр дагаж мөрдөж байгаа зарим дүрэм, журамд өөрчлөлт оруулах.	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамнаас нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг Хууль зүйн яаманд бүртгүүлэн ажилласан байна.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайд нарын 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хамтран баталсан А/169/93 тоот “Гэрээний загварыг шинэчлэн батлах тухай” тушаалыг бүртгүүлхээр хүргүүлсэн. Мөн одоо хэлэлцэгдэж байгаа д</p>

9	Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг цахим хуудсан байршуулах нийтэд мэдээлэх арга хэмжээ авах.	Өргөдөл, гомдол, хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг нэгтгэн байршуулах.	<p>Яаманд хандан иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг яамны www.meds.gov.mn цахим хуудсаны мэдээллийн хэсэгт сар бүрээр байршуулан ажиллаж байна.</p> <p>Энэхүү хэсэгт иргэд, аж ахуй нэгж байгууллагууд нэвтрэн орж өөрийн өгсөн өргөдөл, гомдол хаана ямар мэргэжилтэнд цохогдож очсон, өргөдөл, гомдлын хугацаа хэтэрсэн эсэхэд хяналт тавих боломжтой болсон.</p> <p>2014 оны 10 дугаар сарын 24 ны байдлаар Боловсрол, шинжлэх ухааны яаманд нийт 2065 өргөдөл, гомдол ирснээс 1850 өргөдөл, гомдолд хариуг өгсөн байна.</p> <p>Засгийн газрын 11-11 төвөөс болон яамны 12-06 дугааруудад нийт 1674 санал, хүсэл ирүүлснээс 1656-г шийдвэрлж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Санал 435 ирснээс 433 шийдвэрлэсэн; • Гомдол 318 ирснээс 311 шийдвэрлэсэн; • Талархал 3 ирсэн; • Шүүмжлэл 48 ирснээс 48 хариуг өгч шийдвэрлэсэн; • Хүсэлт 47 ирснээс 44 хариу өгсөн; • Асуулт 823 ирснээс 818 хариуг өгч ажилласан байна. <p>Иргэдийг хүлээж авах хуваарийн дагуу сайдтай 95, дэд сайдтай 111, төрийн нарийн бичгийн даргатай 131 иргэдийг уулзуулан санал, гомдол, хүсэлтийг нь хүлээн авч, цаг алдалгүй шуурхай шийдвэрлэн тэдний зарим бүтээлч санал, санаачлагыг салбарын</p>
---	--	---	---

		<p>бодлогын чанартай баримт бичигт тусгахад анхаарч ажилласан болно.</p> <p>Улсын Их Хурлын гишүүдээс 93, Ерөнхийлөгчийн тамгын газраас 2, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 10, нийт 105 иргэд, байгууллагын хүсэлт тус яаманд уламжлагдан ирсний 96 буюу 95,5 хувийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, үлдсэн 4,5% нь хугацаа болоогүй судлагдаж байна.</p> <p>Энэхүү мэдээлэлд 2014 оны 11,12 дугаар сарын шийдвэрлэлтийн байдал ороогүй болно.</p> <p>Түүнчлэн Шинжлэх ухаан технологийн их сургуулийн цахим хуудсыг шинэчилж, мэдээлэл авахад хялбар, ойлгомжтой байдлаар засан сайжруулан мэдээлэл, санал хүсэлт, гомдол, шүүмжлэлийг ШУТИС-ийн хөгжлийн хэлэлцүүлэг must.edu.mn /must-comment/ хаягаар хүлээн авч, хариу өгөх боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн багш ажилтан, оюутан суралцагчдын санал хүсэлтийг авах зорилгоор санал хүсэлтийн хайрцаг ажиллуулж байна. Мөн ШУТИС-ийн хэмжээнд бичгэн байдлаар 2014 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар 3905 өргөдөл гомдол ирснээс оюутан суралцагчдаас элсэн болон шилжин суралцах, давхар мэргэжил эзэмших, тэтгэлэгт хамрагдах, үргэлжлүүлэн суралцах гэх мэт 1135 өргөдөл хүсэлт, багш ажилтан ажилчдаас байрны квотонд хамрагдах, эмчилгээний зардал болон тусламж тэтгэмж гаргуулах, гадаадад сургалтанд хамрагдах, чөлөө олгох болон чөлөөний хугацаа сунгах, тэтгэвэрт тогтоолгох тухай 122 өргөдөл гомдол ирсэн. Эдгээр гомдол хүсэлтийн хариуг цаг хугацаанд нь өгч шийдвэрлэсэн байна.</p>
--	--	--

10	<p>Гомдол мэдээлэл хүлээн авах утас /Засгийн газрын 11-11, яамны 12-06 дугаар болон бүх төрлийн цахим хэлбэр/ ажиллуулж, мэдээллийн мөрөөр тодорхой арга хэмжээ авах.</p>	<p>Авлига авсан гэх мэдээлэл, нөхцөл байдал үүссэн байж болзошгүй байдлыг нягтлаж мэдээлэл өгөгчдийн нууцыг хангах арга хэмжээ авах.</p> <p>Яамны мэдээллийн самбарт тодорхой мэдээлэлд хариулт өгөх албан тушаалтны утасны дугаар болон бусад холбогдох хаягийг байршуулах.</p>	<p>Иргэд байгууллагаас авлигын талаарх мэдээ мэдээлийг нууц хэлбэрээр авах зорилгоор яамны үүдэнд байрлах мэдээллийн самбарт тусгай цоож бүхий хайрцаг байрлуулсан.</p> <p>2014 оны 10 дугаар сард болон яамны “Нээлттэй хаалганы өдөр”-өөр иргэнд зориулан мэдээллийн гарын авлага хэвлүүлэн тараасан. Үүнд: Иргэдийн түгээмэл асуудаг яамны бүтэц, чиг үүрэг, хариуцах асуудал, холбоо барих хаяг, утас, зөвлөгөө зэргийг тусгасан.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны яаманд хандаж ирсэн иргэн, аж ахуй нэгж байгууллагын албан хаагчыг угтан авч мэдээ мэдээлэлээр хангах, хүссэн мэдээлэлд хариулт өгөх, зөвлөн туслах мэргэжилтнүүдтэй холбох чиг үүрэг бүхий УГТАХ ҮЙЛЧИЛГЭЭГ бий болгон ажиллаж байна.</p> <p>Иргэд аж ахуй нэгж байгууллагад зориулж яамны www.meds.gov.mn цахим хуудсанд МЭДЭЭЛЭЛ ЗАХИАЛАХ хэсэг нээж ажилуулсан. Энэхүү хэсэгт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Яамны цахим хуудсанд мэдээлэл хэрхэн захиалах /ямар мэдээлэл хэрэгтэй байгаа талаар санал өгөх/ 2. Түгээмэл 10 асуудлаар хаанаас, хэрхэн мэдээлэл авч болох талаарх зөвлөмж 3. Бусад асуудлаар хаанаас хэрхэн мэдээлэл авах талаарх зөвлөмж болон холбогдох сайт, утасны дугаар зэргийг байршуулсан. <p>Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас тус яаманд санал, хүсэлтийг ангилж үзвэл:</p>
----	---	--	--

			<ul style="list-style-type: none"> • Бичгээр 437; • Засгийн газрын "11-11" төвөөс хуваарилагдан 393; • Яамны вэбсайт болон и-мэйл хаягаар 195; • Биечлэн ирж өгсөн 213; • Фэйсбүүк, твиттерээр 143; • Утсаар буюу яамны 12-09 дугаарт 275 захидал, өргөдөл, гомдол, санал, хүсэлт нийт 1674 ирснээс 1656 буюу 95.2 хувийг шийдвэрлэж, зохих журмын дагуу хариу өгсөн бөгөөд үлдсэнд нь хариу өгөх хуулийн хугацаа болоогүй судлагдаж байна. <p>МЭДЭЭЛЛИЙН БУСАД СУВАГ гэсэн хэсэгт иргэд ямар мэдээллийн их сурвалжаар мэдээлэл өгч болхыг зааж өгсөн. Олон нийтэд түгээмэл хэрэглэдэг 10 сувагаар өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг авч байгаа.</p> <p>Жиш: Facebook, Twitter, Youtube, иргэдэд үйлчилэх төв г/м –ээр авч байна.</p> <p>“Өргөдөл, гомдол” гэсэн тусгай баннер байрлуулан urgodol@mecs.gov.mn гэсэн хаягаар иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч тухай бүр нь цахим хэлбэрээр тэдэнд хариу өгч ажиллаж байна</p>
Гурав. Санхүү, эдийн засаг			
11	Салбарын болон яамны тухайн жилийн төсвийн тогтмол хувийг авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах арга хэмжээ авах	Тухайн жилд шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж төсөвт тусгах. Батлагдсан хөрөнгийг төлөвлөсөн ажилд зарцуулж тайлагнах	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудсанд ИЛ ТОД ТӨСӨВ, САНХҮҮ гэсэн булан нээж ажиллуулаж байна.</p> <p>Энэхүү буланд:</p> <ul style="list-style-type: none"> • Төсөв, тодотгол дэд хэсэгт

12	<p>Яамны төсөв санхүүгийн мэдээ, мэдээллийг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт бүрэн байршуулах арга хэмжээг авах.</p>	<p>Яамны цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээ мэдээллийг тусгаж байх.</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны төсвийн төсөл, мөн он оны салбарын төсвүүдийг байршуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн гүйцэтгэл дэд хэсэгт Боловсрол, шинжлэх ухааны яамны 2013 он болон өмнөх оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгуудыг байршуулсан. • Аудитын дүгнэлт дэд хэсэгт Боловсрол, шинжлэх ухааны яамны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтүүд 2013 он болон өмнөх онуудын тайлан, дүгнэлтийг байршуулсан. • Төсвийн төсөл дэд хэсэгт Боловсрол, шинжлэх ухааны яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2012-2014 оны төсвүүд, 2015 оны төсвийн төсөл зэргийг байршуулсан. • Санхүүгийн тайлан дэд хэсэгт Боловсрол, шинжлэх ухааны яамны санхүүд хийсэн тайлангуудыг байршуулсан. • Төлбөр хураамж дэд хэсэгт Боловсрол, шинжлэх ухааны яамны кассан орсон бэлэн мөнгөний орлого зэргийг дэд хэсгүүдэд оруулж өгсөн. <p>Боловсрол, шинжлэх ухааны харьяа байгууллагууд өөрсдийн цахим хуудсанд Мэдээ мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нийтэд мэдээлэх мэдээллүүдийг бүрэн байршуулж хэвшсэн.</p>
13	<p>2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудсанд байршуулах.</p>	<p>Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг сонирхсон иргэд байгууллага хуульд заасан үндэслэл журмын дагуу үзэх боломжыг нээх.</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамны цахим хуудсанд ИЛ ТОД ХУДАЛДАН АВАЛТ гэх булан нээсэн. Энэхүү буланд дараах дэд хэсгүүдэд мэдээ, мэдээллүүдийг оруулсан.</p>

		<p>Тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй оролцогчдын мэдээллийг цахим хуудсанд оруулах.</p>	<ul style="list-style-type: none"> • Тендерийн урилга дэд хэсэгт Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зарлаж байгаа худалдан авах ажиллагаа буюу тендерүүдийн зарыг байршуулсан.
		<p>Худалдан авах ажиллагаанд хийгдсэн тайланг тухай бүр нь цахим хуудсанд байршуулах.</p>	<ul style="list-style-type: none"> • Тендерийн төлөвлөгөө дэд хэсэгт Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2014 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний жагсаалтыг байршуулсан. Энэ хэсэгт <ul style="list-style-type: none"> Бараа худалдан авах төлөвлөгөө; Ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө; Сурах бичиг хэвлэн нийлүүлэгч сонгон шалгаруулах тендерийн төлөвлөгөө гэж тус бүрт нь ангилж оруулсан. • Хууль тогтоомж дэд хэсэгт Тендэр шалгаруулалттай холбогдсон хууль тогтоомжийг иргэд аж ахуй нэгжид зориулж байршуулсан. • Аудитын дүгнэлт дэд хэсэгт Худалдан авах ажиллагаа болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтүүдийг байршуулсан. • Тендер шалгаруулалт дэд хэсэгт Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зарласан тендэрт шалгарсан аж ахуй нэгжүүдийн жагсаалтыг байршуулсан. • Тендерийн тайлан дэд хэсэгт Захиалагчын 2013 оны бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын тайлан болон өмнөх оны тайлангуудыг байршуулсан. • Журам, заавар дэд хэсэгт Иргэд аж ахуй нэгж байгууллагуудад зориулж худалдан авах ажиллагаатай холбогдол бүх дүрэм, журам, үнэлгээний заавар зэргийг байршуулсан. • Өргөдөл, гомдол дэд хэсэгт Иргэд аж ахуй нэгж байгууллагаас худалдан авах ажиллагаатай холбогдуулж ирүүлсэн

			<p>өргөдөл гомдлын шийдвэрлэлт нь яамны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн бүртгэлд орсон.</p> <p>Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллүүдийг яамны цахим хуудсан тогтмол мэдээлж байна. Мөн Засгийн газрын худалдан алах ажиллагааны газрын www.e-procurement.mn байршуулж байна.</p> <p>Соёл Урлагын Их сургууль нь Улсын төсвийн хөрөнгөөр буюу Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийт 660.0 сая төгрөгийн 4 нээлттэй тендер, тус сургуулийн цайны газрын сонгон шалгаруулалтын 1 урилгыг өдөр тутмын хэвлэл болох Өнөөдөр сонин, Сангийн яамны www.e-procurement.mn тус сургуулийн www.msuac.edu.mn вэб хуудсанд тус тус байршуулсан.</p>
Дөрөв. Хүний нөөц			
14	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжинд заасны дагуу тодорхой төрлийн зарим ажлын байранд алба хаагчдыг сэлгэн ажиллуулах арга хэмжээ авах.</p>	<p>Яамны зарим ажлын байран дээр албан хаагчдыг сэлгэн ажиллуулах талаар судлан, хэрэгжүүлэх арга хэмжээ авах.</p>	<p>Тус яамнаас 2014 онд нийт 22 ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжын дагуу нийтэд зарласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Яаманд 10 • Лабортори сургуулийн захиралын 9 • Харьяа байгууллагын захиралын 3 ажлын байранд тус тус нээлттэй сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. <p>Үүнээс лаборатори сургуулийн захиралын 9 ажлын байранд нийт 28 хүн холбогдох материал бүрдүүлж өгсөн. Материал бүрдүүлж сонгон шалгаруулалтанд орсон 28 хүнээс 6 хүн тэнцэж, 3 захиралын ажлын байрны сонгон шалгаруулалтыг дахин зарлахаар болсон.</p>

			<p>Хүний нөөцийн мэдээ, мэдээллийг яамны цахим хаяг болон төрийн албаны зөвлөлийн цахим сайтад тогтмол байршуулж байгаа.</p>
15	<p>Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн аливаа авлигатай холбоотой асуудлыг АТГ-т мэдээлэх.</p>	<p>Авлигын талаар нэг мөр ойлголттой болох, Авлигад өртсөн байх магадлалыг АТГ-т мэдээлэх арга хэлбэрийг албан хаагчдад таниулах.</p>	<p>Яамны болон харьяа байгууллагын албан хаагчид албан үүргээ гүйцэтгэж явах үедээ мэдсэн Авлигын талаарх мэдээ, мэдээллийг хэрхэн шийдвэрлэх, холбогдох байгууллагад яаж хүргүүлэх талаарх заавар, зөвлөгөөг хууль тогтоомжид заасны дагуу Эрх бүхий албан тушаалтан биечлэн болон утас болон бусад эх үүсвэрээр өгч ажиллаж байна.</p> <p>Мөн энэ чиглэлд салбрын Эрх бүхий албан тушаалтануудад үүрэг чиглэл өгч ажиллаж байна.</p>
16	<p>Сул орон тооны мэдээ, мэдээлэл, сонгон шалгаруулах журамтай холбоотой мэдээллийг цахим хуудсанд байршуулах талаар арга хэмжээ авах.</p>	<p>Хүний нөөцийн стратеги, хэрэгжилтийг хянаж, үнэмлэх, хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах.</p>	<p>Төрийн албан зөвлөлийн даргын 2013 оны 60 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлагдсан журмын дагуу Боловсрол, шинжлэх ухааны яаманд ажил орох хүсэл сонирхолтой иргэдэд яамны сул орон тоо болон сонгон шалгаруулалтын хувиарыг яамны www.mecs.gov.mn цахим хуудсан тухай бүр байршуулан ажилласан.</p> <p>2014 онд Боловсрол, шинжлэх ухааны яаманд сул 10 орон тоонд сонгон шалгаруулж орон тоог нөхсөн, Лабортори сургуулийн захиралын 9 орон тоонд сонгон шалгаруулалт зарлаж шаадлагад нийцсэн 6 хүнийг авч 3 сул орон тоон дээр дахин зарлахаар болсон, яамны харьяа 3 байгууллагын удирдах албан тушаалтны сул оронд тоог нийтэд зарлаж, сонгон шалгаруулалтыг явуулж нөхсөн.</p>

			<p>Сонгон шалгаруулалтанд тэцсэн иргэдийн материалыг холбогдох журмын дагуу Төрийн албаны зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлсэн.</p> <p>ШУТИС-иас 2014 онд багшийн албан тушаалд 20, эдийн засаг статистикчийн албан тушаалд 1, бүрэлдэхүүн сургуулийн захирлын албан тушаалд 9, бүрэлдэхүүн сургуулийн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын 39 сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулахаар өдөр тутмын Өдрийн сонин, Өнөөдөр сонин, Үндэсний шуудан сонин болон сургуулийн цахим хуудсаар сул орон тооны талаар зарлаж нийтэд мэдээлсэн болно.</p> <p>2014 онд “СУИС-ийн профессорын баг, тэнхимд тавигдах шаардлага, профессор багшийн албан тушаалд сонгон шалгаруулж ажиллуулах журам”-д заасны дагуу шинээр ажилд авах багш нарын сонгон шалгаруулалтыг хичээлийн жилийн хаврын болон намрын улиралд нийт 2 удаа, тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах зарыг нийт 2 удаа, ажилтан ажилчид сонгон шалгаруулах зарыг нийт 4 удаа явуулсан бөгөөд ажлын байрны зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох өдөр тутмын хэвлэл болох Өнөөдөр сонин, сургуулийн www.msuac.edu.mn вэб хуудсанд тус тус байршуулсан болно.</p>
Хяналт, шинжилгээ, үнэлгээ			
Тав. Авлигын эсрэг хууль тогтоомж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах			

17	<p>Яамны нэгж болон харъяа байгууллагууд дээр төлөвлөгөөний биелэлтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж холбогдох арга хэмжээ авах.</p>	<p>Харъяа байгууллага дээр төлөвлөгөөний хэрэгжилт, ил тод байдлыг хэрхэн хууль тогтоомжид нийцүүлэн хангуулж байгаад хяналт хийж, үнэлгээ өгөх.</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2014 онд дараах чиглэлээр дотоод аудитын хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>1. “Бага дунд боловсролын чанарын шинэчлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 8 багийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод аудит хийж, Аудитын үр дүн, аудитын тайлан, зөвлөмжийг хүргүүлсэн болно.</p> <p>Уг хөтөлбөрийг хэрэгжүүлж буй менежментийн болон хэрэгжилтийн 8 багийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод аудит хийж, цаашид хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай 12 төрлийн зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг хүргүүлсэн. /биелэлтийг ирүүлээгүй байна./</p> <p>2. Захиалагат аудитаар Монгол улсын засгийн газар, Кембрижийн их сургуулийн олон улсын шалгалтын төв хоорондын “Боловсролын үйлчилгээ үзүүлэх тухай” хэлэлцээрийн хэрэгжилт, нийт зарцуулсан хөрөнгийн тооцоог гаргах, санхүүгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор дотоод аудит хийлээ. Дотоод аудитаар Боловсролын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж эхэлсэн 2011 оноос 2014 оны 2-р улирлыг дуусталх хугацааг хамруулсан бөгөөд тайлант хугацаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийг зардлын ангилал тус бүрээр нэгтгэн гаргаж, тайлагнасан.</p> <p>3. МУИС-ийн захирал Д.Галтбаяртай холбоотой “Оюутан шилжүүлэн суралцуулах журам” зөрчсөн, дүн зассан асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу холбогдох баримт бичигтэй тулган баталгаажуулах замаар дотоод аудитыг хийж, Авилгалтай тэмцэх газраас ирүүлсэн баримт, тодруулга хүсэх тухай албан тоотын дагуу холбогдох дүгнэлт, зөвлөмжийг Авилгалтай тэмцэх газарт хүргүүлсэн болно.</p>
----	--	--	--

			<p>4. Засгийн газрын шийдвэрийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны эхний хагас жилийн Худалдан авах ажиллагааны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор Сангийн яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй хамтран дотоод аудитын ажлыг гүйцэтгэж, цаашид хэрэгжүүлэн ажиллах шаардлагтай 9 төрлийн зөвлөмжийг өгч, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг боловсруулан хүргүүлсэн. /биелэлт тооцох хугацаа болоогүй байна./</p> <p>5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013-2014 оны төсвийн багц дахь Засгийн газрын нөөц сангийн хөрөнгө болон “Төвлөрсөн арга хэмжээ”-ний зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хэрэгжилтийн үр дүнд Сангийн яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс томилогдсон дотоод аудитын ажлын багтай хамтран дотоод аудитын ажил хийгдэж, цаашид хэрэгжүүлэн ажиллах шаардлагтай 6 төрлийн зөвлөмжийг өгч, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг хүргүүлсэн. /биелэлт тооцох хугацаа болоогүй байна./</p> <p>6. Монгол Улсын Их Сургуулийн Олон Улсын Харилцааны Сургуулийн багш П.Лхамсүрэнгийн Авлигатай тэмцэх газарт хандан гаргасан өргөдөлд дотоод аудит хийлээ. Дотоод аудитын явцад хууль тогтоомж зөрчсөн зөрчил илэрсэн тул илэрсэн зөрчлийг хууль тогтоомжид нийцүүлэх, төсвийн зарцуулалтыг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг зөвлөмжөөр</p>
--	--	--	---

			<p>хүргүүлж зөвлөмжийн биелэлтийг тооцон ажилласан.</p> <p>Салбар болон харъяа байгууллагууд 2014 онд дотоод аудитын чиглэлээр хийсэн байдал:</p> <p>1. Үндэсний Анагаахын Шинжлэх Ухааны Их сургууль нь дараах хяналт шалгалт, дотоод аудитыг хийж ажилласан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• 2013 оны 10 сарын 15-ны өдөр бүрэлдэхүүн сургуулиудын захирлын ажлын гүйцэтгэлд дотоод аудитыг Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолын зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, их сургуулийн бичиг хөтлөлтийн дүрэм, ЭМШУИС-н дотоод дүрэм, журамын дагуу шалгаж Албан бичиг хөтлөлт, захиргааны ажлын зохион байгуулалтын ажлын төлөвлөгөөний түвшин тогтоож Зохих журам, дүрмийн дагуу ажиллах, захиргааны ажлыг албажуулалтыг сануулах, төлөвлөлтийг сайжруулах зөвлөмж хүргэв.• ЭМШУИС-ын элсэлт болон шилжилт хөдөлгөөний тушаалуудад дотоод аудитыг Боловсролын тухай хууль, Авилгын эсрэг хууль, БШУЯ-ны сайдын тушаалууд ЭМШУИС-дүрэмийн дагуу Оюутны элсэлт, шилжилт хөдөлгөөний тушаалгүй оюутан суралцсан болон UNIFACE оюутны дүн, бүртгэлийн доголдол илэрсэн тул Сургуулийн элсэлтийн дүрмийг зөрчин тушаалгүй оюутан элсүүлэх, шилжүүлэх, дүнгийн зөрүү гарах гэх мэт алдаа байсан. Дээрхи асуудалд хариуцлаггүй хандсаноюутны албаны ААЗ Н.Балжмаа нь өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан байна. Мөн захиргаанд зарим ажилтанд /Н.Түмэндэмбэрэл, Ч.Зиймаахүү, Б.Алтанзул/ хариуцлага тооцон ажлаас чөлөөлж, оюутны
--	--	--	--

			<p>бүртгэл болон сургалтын үйл ажилгааг хариуцсан мэргэжилтэн нарт сануулсан болно.</p> <ul style="list-style-type: none">• ЭМШУИС-ын Сувилахуйн сургуулийн элсэлт болон шилжилт хөдөлгөөний тушаалуудад хийсэн дотоод аудитыг Оюутны алба, Сургалтын бодлого зохицуулалтын газаруудаас Боловсролын тухай хууль, Авилгын эсрэг хууль, БШУЯ-ны сайдын тушаалууд ЭМШУИС-дүрэмийн дагуу Оюутны элсэлт, шилжилт хөдөлгөөний тушаалууд болон UNIFACE оюутны бүртгэлийг дутагдалыг дүгнэх, зөрүүтэй төлбөрт үйл ажилгааг тодруулахаар ажилласан бөгөөд үүнээс Мөн төв сургууль дээр илэрсэнтэй мөн ижил алдаа дутагдал илэрсэн. Сургалтын албаны дарга Оюунцэцэг, мэргэжилтэн Амартүвшин, хүний нөөцийн мэргэжилтэн Нармандах нарт цалингын арга хэмжээ авсан. Сургалтын үйл ажилгаанаас гадна БШУЯ-ны сайдын болон ЭМШУИС-н захирлын тушаалыг зөрчин оюутнаас эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээр зөрүүтэй төлбөр хураан авч сувилахуйн сургуулийн дансанд байршуулж байсан нь илэрсэн.• ЭМШУИС-ын үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалтын байдалд үнэлгээ хийх дотоод аудитаар Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТӨХ-ны зохих журам, ЭМШУИС-н дотоод дүрэм, журамын дагуу Үнэлгээний байдал : Сайн: ИСНЭ; НЭМ; ЭЗ; БА тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал хэвийн төвшинд ашиглаж байна. Дунд: АУС; УАУ тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал дунд зэрэг үйл ажилгаага бага явуулж байна. АУС-н ур чадварын төвд хадгалагдаж байсан 7 нэтбоок болон 1 вэбкамер 1 вэб гар утасыг хураан авч зохих засвар үйлчилгээг хийлгэн багш ажилчдад хэрэгцээнд хэрэглүүлхээр
--	--	--	--

		<p>тараан өгсөн. Хүүхдийн тэнхимд байрлах нярайн мандалтын лабораторийн багажийг сургуулийн дансанд бүртгүүлсэн. Дундаас доогуур: СС; НАСС-н сургуулийн ко1са-н төслийг тодорхой болгох шаардлагатай байна. СС-н хувьд мянганы сорилийн сангийн ашиглалт муу байдалтай байлаа. Гүйцэт хүлээж авсан байдал муу зарим нэг тоног төхөөрөмж ирээгүй байсан.</p> <ul style="list-style-type: none">• Эрхэс сувилалын зайлшгүй хийх урсгал засварын ажлыг жагсаалт гарган захиралд танилцуулсан. Сувилахуйн сургуулийн хэвлэх үйлдвэр нь бизнесийн чанартай үйл ажиллагаа явуулан оюутнуудаас мөнгө хурааж авсан байна. БШУЯ-ны сайдын сургалтын үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд төлбөр авахгүй байх гэсэн тушаалыг зөрчсөн. Нийт 466 оюутнаас 4500 төгрөг, 421 оюутнаас 45000 төгрөг, 414 оюутнаас 95000 төгрөг нийт 60372000 төгрөг хурааж авхаар төлөвлөн ажиллаж байснаас 55632000 хурааж аван 4740000 төгрөг-ийн үлдэгдэлтэй байгаа гэж тайлагнасан байна. Зөрчлийг засуулах зөвлөмж хүргүүлэх гэж байна. <p>2. Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлэн 2014 онд бүрэлдэхүүн сургуулиудын захиргаа, сургалт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх төлөвлөгөөг Хөгжлийн бодлого мониторингийн газрын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу тухайн үеийн Барилгын инженер архитектурын сургууль, Геологи газрын тосны сургууль, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Механик инженерийн сургууль, Үйлдвэрлэлийн технологи дизайны сургуулиудын захиргаа, сургалт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд</p>
--	--	---

			<p>төлөвлөгөөт хяналт шалгалтыг явуулан холбогдох дүгнэлт зөвлөмжийг өгсөн. Түүнчлэн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2013/2014 оны хичээлийн жилийн хаврын улирлын төгсөгчдийн дипломын материал, 2014/2015 оны хичээлийн жилд ШУТИС-д шинээр элсэгчдийн ерөнхий шалгалтын оноо, элсэлтийн материал, ШУТИС-ийн хэвлэлийн үйлдвэр сугалтын төвийн 2013 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт шалгалтыг явуулан холбогдох дүгнэлт зөвлөмжийг өгч ажилласан.</p>
--	--	--	---